

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН
ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

АМГТГ-ын даргын 2025 оны 4-р сарын 23-ны өдрийн 1/1908 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт Зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хүргүүлж биелэлтийг гарган ажиллаж байна.

1. Төлбөр барагдуулах тухай акт:

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тусгай зөвшөөрлийн төлбөрийг 1 гэрээлэгч 6.0 мянган ам.доллараар буюу 20,461,191.00 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх

Авсан арга хэмжээ:

Гэрээний дагуу төлөх Зонхэн Юан Тиан ХХК-ийн тусгай зөвшөөрлийн дутуу төлбөр болох 5,982 ам.долларыг ойрын хугацаанд төлүүлэхээр удаа дараа буюу 2025 оны 1-р сарын 28-ны өдрийн 3/401, 2025 оны 5 сарын 28-ны өдрийн 1/2576 тоот албан бичгүүдээр тус тус мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

2. Албан шаардлага:

Аудитаар 7 албан шаардлага ирүүлснийг үйл ажиллагаандаа тусган холбогдох арга хэмжээ авч биелэлтийг гарган ажиллаж байна. Үүнд:

2.1 Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой ажил гүйлгээний анхан шатны бүртгэл хөтлөлт буюу холбогдох мэргэжилтнүүдээс тухайн жилийн улсын төсвийн орлогын ногдуулалт, төлөлт, тооцооны үлдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналт сул, нягтлан бодох бүртгэлтэй уялдаагүй байна. Тус зөрчлийг арилгуулахаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Авсан арга хэмжээ : Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлтэй уялдуулах, удирдлагаас тавих хяналтыг сайжруулах талаар анхаарч Улсын төсвийн болон үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг илүү сайжруулан Сангийн сайдын 2023 оны №65 тоот тушаалаар батлагдсан “Аккруэл суурьт Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн дагуу үе шаттайгаар 2024-2026 онд аккруэл сууриар орлого хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаанд шилжихээр холбогдох хууль тогтоомж, дүрэм журам дээр ажиллан, зарим орлого хариуцсан албан хаагчдын ажлын уялдааг сайжруулах үүднээс бүтэц

орон тоонд өөрчлөлт оруулж байна. Дээд шатны шийдвэрээс шалтгаалан зарим тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхэд удааширсан тул цаашид зөвлөмжийг хэрэгжилтэнд анхааран ажиллаж байна.

2.2 Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, хариуцлага сул, үр дүнг үнэлж дүгнээгүй байгаа нь тус хөрөнгө зориулалт бусаар, үр дүнгүй зарцуулагдах эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн байна.

Авсан арга хэмжээ: 1. Суралцагчдын сургалтын төлбөр төлсөн тухай тайланг жил бүр Төрийн захиргааны төв байгууллагад гарган өгч хянуулан тухайн жилийн сургалтын зардлыг зарцуулах төлөвлөгөөг яамны Төрийн нарийн бичгийн даргаар журмын дагуу тушаалаар батлуулж ирсэн.

2. Төгсөгчид сургууль төгсөж ирээд албан хүсэлт өгдөг боловч ажлын байрны сул орон тоо байхгүй тул өөрийн хүсэлтээр орох боломжтой байгууллагад мэргэжлээрээ ажиллахыг санал болгоод явуулдаг.

3. Суралцагчдын сургалтын явцад дүнгийн жагсаалтыг авч хяналт тавин, үнэлгээ шаардлага хангасныг үндэслэн тухайн жилийн сургалтын төлбөрийг шилжүүлдэг.

4. Гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдэх талаар дурьдаагүй, гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно гэж заасан байна. Иймд сургууль төгссөн баримт, гэрчилгээг үндэслэн гэрээг дуусгавар болсонд тооцсон байгаа бөгөөд 2021-2024 онд төгссөн дипломаа авсан 17 суралцагчийн баримтыг хувийн хэрэгт нь авч гэрээг дуусган, төгссөн боловч дипломаа авч амжаагүй байгаа 6 суралцагч, төгсөөгүй 4 суралцагчтай тооцоо хийж гэрээний хэрэгжилтийг сануулан холбогдох арга хэмжээг авч ажиллаа.

5. 2014-2021 оны суралцагчдын мэдээллийн сан, хувийн хэргийг архивласан. 2024 онд суралцаж буй оюутнуудын хувийн хэрэг бүрэн материалтай, хөтлөгдөж байна.

2.3 Сургалтын урамшууллын хөрөнгөөс богино хугацааны сургалтад албан хаагчдыг сургаж, сургалтын төлбөр олгож байгаад дотоод хяналтгүй, нарийвчилсан зохицуулалтгүй, сургалтын үр дүнг тооцож үнэлээгүй, суралцагчид бүрээр тооцоо үүсгэж бүртгээгүй, тухай бүр шууд зардлаар хүлээн зөвшөөрч байна.

Авсан арга хэмжээ: Сургалтын урамшууллын хөрөнгө зарцуулах Засгийн газрын 2013 оны 291-р тогтоол, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын дагуу даргын тушаалаар 1 жилээс дээш хугацаагаар суралцаж байгаа 22 албан хаагчийн /хамаарах зардал нь 72,114,800 төгрөг / тухайн сургалтын байгууллагатай хийсэн гэрээ, дүнгийн хуудас, суралцаж байгаа тухай тодорхойлолтыг үндэслэн төлбөрийг шууд зардлаар хүлээн зөвшөөрсөн болно. 2025 онд дотоодын суралцагч нартай нэг

бүрчлэн гэрээ хийн үүрэгжүүлж, суролцогч тус бүрээр тооцоо үүсгэн үр дүнг тооцож байна.

Тухайн жилд гаргасан зардлын гүйцэтгэлийг тайлангийн хамт жил бүр дээд шатны төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн хянуулж байна.

2.4 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийг хийж буй 8 хуулийн этгээдтэй байгуулсан Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний дагуу автомашин /жиип ангиллын туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй/-ыг нийлүүлэх заалтын хэрэгжилтийг хангаагүй, Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс 2007-2017 онуудад эрлийн гэрээний хүрээнд хүлээн авсан, бүртгэлгүй 7 авто машиныг ашиглалтгүй болсон 4 авто машиныг компаниудад буцаан хүлээлгэн өгөх, ашиглалтад буй 3 авто машиныг бүртгэлд тусгахаар шийдвэрлэсэн ч, хэрэгжилтийг ханган ажилаагүй байна.

Авсан арга хэмжээ: Газрын тосны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д заасны дагуу эрлийн ажил гүйцэтгэх гэрээг гурав хүртэл жилийн хугацаагаар байгуулдаг. Тус гэрээний 3.4.10-т "Компани энэхүү гэрээний 3.1.3-т заасан АМГТГ-аас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашиныг худалдан авч АМГТГ-т буцалтгүйгээр өгнө" гэж заасан байдаг. Энэ нь эрлийн гэрээт хугацаанд хэрэгжих заалт бөгөөд автомашиныг ямар хугацаанд хүлээлгэн өгөхийг гэрээнд нарийвчлан заагаагүй тул тухайн гэрээлэгч байгууллагаас шаардахад гэрээ дуусаагүй, эрлийн ажилд ашиглаж байгаад гэрээ дуусах үед өгнө гэх тайлбар өгдөг бөгөөд тухайн гэрээлэгч компаниудад зөвлөмж хэрэгжүүлэх талаар мэдэгдэл хүргүүлэн ажиллаж 2025 оны эхний 6 сарын байдлаар 3 байгууллагаас санал ирж 2 автомашиныг хүлээн аваад байна.

2.5 Газрын тосны мэргэжлийн чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 35 оюутанд байнгын хорооны 2023 оны 4 дүгээр тогтоол, МУЗГ-ын 2021 оны 241 дүгээр тогтоолыг үндэслэн, нээлттэй сонгон шалгаруулалтгүйгээр нийт 263,059.7 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн нь МУЗГ-ын 2013 оны 291 дүгээр тушаалаар баталсан журамтай нийцээгүй байна.

Авсан арга хэмжээ :

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны /хуучнаар/ төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/37 тоот, 2024 оны А/50 тоот тушаал, УИХ-ын байнгын хорооны 2023 оны 4-р тогтоол, МУЗГ-ын 2021 оны 241 дүгээр тогтоол, Шадар сайдын 2021 оны 87 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн 2024 оны хувьд ШУТИС-тай гэрээ байгуулан суралцагчдын дүн, сургуулийн тодорхойлолтын дагуу төлбөрийг шилжүүлсэн. Сургалтын хөрөнгө зарцуулах МУЗГ-ийн 2013 оны 291 дүгээр тогтоолоор дотоодын их дээд сургуульд суралцах иргэдийг сонгон шалгаруулалтын комисс байгуулах, зарлах эрх нь уул уурхай, боловсролын асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагуудад байдаг бөгөөд энэ талаар холбогдох байгууллагад хандан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна. 2025 онд шилжүүлсэн төлбөр байхгүй байна.

2.6 Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөөлөгчийн дэмжих сангийн хөрөнгөөс худалдан авч буй, 56,343.7 мянган төгрөгийн авто машины сэлбэг

хэрэгсэл, засвар үйлчилгээ, 31,090.2 мянган төгрөгийн урсгал засвар, 19,928.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 14,615.0 мянган төгрөгийн шатахуун зэргийг тусгаж батлуулаагүй байна.

Авсан арга хэмжээ :

Байгууллагын урсгал зардал болон Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгөнөөс авах худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахад эх үүсвэр, нэр төрлөөрөө тус тусдаа ордог тул худалдан авах ажиллагааны цахим системд мэдээллийг оруулахад зарим зүйлийг орхигдуулсан байна. Иймд 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бүх зардлыг нарийвчлан тусган зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаа.

2.7 Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй цайны газар, ариун цэврийн өрөөнүүдийн 124,012.5 мянган төгрөгийн урсгал засварын ажлын гүйцэтгэлд төсөв зохиогчийн хяналт хийлгээгүй, зохиогчийн хяналтад төлөвлөсөн 1,076.7 мянган төгрөгийг нэмэлт ажилд зарцуулж, гүйцэтгэлийг зохиогчийн хяналтын зардлаар тайлагнасан байна.

Авсан арга хэмжээ :

Ариун цэврийн өрөөний урсгал засварын ажлын гүйцэтгэлээр захиалагчийн хүсэлтээр хийгдсэн нэмэлт ажлын зардал 5042.0 мян төгрөг гарсан бөгөөд уг зардлыг шийдвэрлэж олгоход төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардал санхүүжилт хүрэлцэхгүй байснаас хүлээн авах комиссын шийдвэрээр нэмэлт ажилд шилжүүлсэн болно. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаа.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР